



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДГА-2021/36/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум

2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Гэрээт ажилтан: Ц.Лүндэгмаа

Утас: 99026829

Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА А.АНХТУЯА ТАНАА

2021.02.24 № 1-6/106  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭНЭ  Т.ГАН-ӨЛЗИЙ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,381,100.00</b>	<b>2,534,900.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	1,000,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	1,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	2,381,100.00	1,534,900.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	2,381,100.00	1,534,900.00
35410	Бичиг хэргийн материал	495,600.00	771,600.00
35420	Аж ахуйн материал	1,885,500.00	763,300.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>59,279,804.37</b>	<b>59,915,371.16</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	59,279,804.37	59,915,371.16
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	59,279,804.37	59,915,371.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	50,829,574.00	50,829,574.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-736,660.44	-1,473,320.88
39203	Авто-тээврийн хэргэсэл	75,000,000.00	75,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-72,395,833.55	-75,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,387,470.00	14,069,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,911,830.00	-6,347,533.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,947,310.00	7,116,310.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,840,225.64	-4,279,058.62
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>61,660,904.37</b>	<b>62,450,271.16</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>61,660,904.37</b>	<b>62,450,271.16</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	61,660,904.37	62,450,271.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	45,528,852.86	45,528,852.86
51101	Өмч: - төрийн	45,528,852.86	45,528,852.86
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-26,187,680.69	-25,384,454.90
51210	Өмнөх үеийн үр дүн	-26,187,680.69	-26,173,821.69
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	789,366.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,319,732.20	42,305,873.20
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>61,660,904.37</b>	<b>62,450,271.16</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>160,703,578.00</b>	<b>180,212,294.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,201,078.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	22,201,078.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,201,078.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,201,078.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>138,502,500.00</b>	<b>180,212,294.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	47,553,494.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	47,553,494.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	138,502,500.00	132,658,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	138,502,500.00	132,658,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>179,137,284.58</b>	<b>179,422,927.21</b>

**Замын-Үүд сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>179,137,284.58</b>	<b>179,422,927.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	150,522,564.58	167,602,559.51
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	60,164,992.00	72,574,723.80
210101	Үндсэн цалин	51,206,487.00	72,574,723.80
210104	Урамшуулал	8,958,505.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,773,190.00	9,074,602.00
210201	Тэтгэврийн даатгал	5,616,223.00	7,700,598.00
210202	Тэтгэмжийн даатгал	535,901.00	226,908.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	305,858.00	305,893.00
210204	Ажилгүйдлийн даатгал	119,538.00	169,768.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,195,670.00	671,435.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,703,289.00	18,290,031.50
210401	Бичиг хэрэг	2,771,508.00	1,892,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,478,000.00	7,789,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	913,781.00	1,215,407.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	7,393,124.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	13,540,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	2,776,000.00
210604	Урсгал засвар	00.00	2,776,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,722,860.00	42,000.00
210702	Дотоод албан томилолт	1,021,000.00	42,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,701,860.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	34,795,227.00	49,568,569.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,680,227.00	49,222,569.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	324,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,363,006.58	15,276,633.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	9,563,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,252,300.00	1,060,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,110,706.58	4,653,433.21
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	28,614,720.00	11,820,367.70
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	11,212,721.00	1,348,367.70
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,401,999.00	10,472,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	8,992,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,401,999.00	1,480,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-18,433,706.58</b>	<b>789,366.79</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	937,000.24	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	937,000.24	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-937,000.24	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-19,370,706.82</b>	<b>789,366.79</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>160,703,578.00</b>	<b>180,212,294.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,201,078.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	22,201,078.00	00.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	22,201,078.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,201,078.00	00.00

**Замын-Үүд сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>138,502,500.00</b>	<b>180,212,294.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	47,553,494.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	47,553,494.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	138,502,500.00	132,658,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	138,502,500.00	132,658,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>160,703,578.00</b>	<b>180,212,294.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>160,703,578.00</b>	<b>180,212,294.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>132,080,858.00</b>	<b>168,271,926.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	60,156,992.00	72,469,723.80
210101	Үндсэн цалин	48,707,287.00	56,456,778.99
210104	Урамшуулал	11,449,705.00	16,012,944.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,773,190.00	9,074,602.00
210201	Тэтгэврийн даатгал	5,396,848.00	6,188,336.00
210202	Тэтгэмжийн даатгал	535,901.00	719,497.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	525,233.00	575,357.00
210204	Ажилгүйдлийн даатгал	119,538.00	236,502.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,195,670.00	1,354,910.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,332,589.00	12,320,907.50
210401	Бичиг хэрэг	2,418,808.00	2,391,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	7,689,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	913,781.00	2,215,407.50
210404	Ном, хэвлэл	00.00	25,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	8,100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,155,000.00
210604	Урсгал засвар	00.00	3,945,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,020,860.00	42,000.00
210702	Дотоод албан томилолт	1,021,000.00	42,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,999,860.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	41,044,927.00	49,568,569.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,929,927.00	49,222,569.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	324,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,752,300.00	16,696,124.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	14,696,224.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,752,300.00	1,999,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,622,720.00</b>	<b>11,940,367.70</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	11,212,721.00	1,348,367.70
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,409,999.00	10,592,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	8,992,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,409,999.00	1,600,000.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	45,528,852.86	12,670,950.00	18,171,354.76	76,371,157.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>45,528,852.86</b>	<b>12,670,950.00</b>	<b>18,171,354.76</b>	76,371,157.62
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,587,342.70	-6,587,342.70
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>45,528,852.86</b>	<b>42,319,732.20</b>	<b>-26,187,680.69</b>	61,660,904.37
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>45,528,852.86</b>	<b>42,319,732.20</b>	<b>-26,187,680.69</b>	61,660,904.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	13,859.00	13,859.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>45,528,852.86</b>	<b>42,319,732.20</b>	<b>-26,173,821.69</b>	61,674,763.37
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-13,859.00	00.00	-13,859.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	789,366.79	789,366.79
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>45,528,852.86</b>	<b>42,305,873.20</b>	<b>-25,384,454.90</b>	62,450,271.16

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хөтөл бөрийн код	Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Өөрчлөлт	Хувь
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
70101	<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	147,443,200.00	132,417,754.30	15,025,445.7	89.8
70101	<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	147,443,200.00	132,417,754.30	15,025,445.7	89.8
70101	<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	135,843,200.00	121,825,754.30	14,017,445.7	89.7
70101	<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	80,352,900.00	72,469,723.80	7,883,176.2	90.2
70101	210101	Үндсэн цалин	64,350,500.00	56,456,778.99	7,893,721.0	87.7
70101	210104	Урамшуулал	16,002,400.00	16,012,944.81	-10,544.8	100.1
70101	<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10,184,800.00	9,074,602.00	1,110,198.0	89.1
70101	210201	Тэтгэврийн даатгал	6,911,500.00	6,188,336.00	723,164.0	89.5
70101	210202	Тэтгэмжийн даатгал	808,800.00	719,497.00	89,303.0	89.0
70101	210203	ҮОМШӨ-ний даатгал	639,600.00	575,357.00	64,243.0	90.0
70101	210204	Ажилгүйдлийн даатгал	157,200.00	236,502.00	-79,302.0	150.4
70101	210205	Эрүүл мэндийн даатгал	1,667,700.00	1,354,910.00	312,790.0	81.2
70101	<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,073,900.00	12,320,907.50	752,992.5	94.2
70101	210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,391,500.00	108,500.0	95.7
70101	210402	Тээвэр, шатахуун	7,689,300.00	7,689,000.00	300.0	100.0
70101	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,407,800.00	2,215,407.50	192,392.5	92.0
70101	210404	Ном, хэвлэл	476,800.00	25,000.00	451,800.0	5.2
70101	<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,100,000.00	8,100,000.00	0.0	100.0
70101	210601	Багаж, техник, хэрэгсэл	4,155,000.00	4,155,000.00	0.0	100.0
70101	210604	Урсгал засвар	3,945,000.00	3,945,000.00	0.0	100.0
70101	<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	881,600.00	42,000.00	839,600.0	4.8
70101	210702	Дотоод албан томилолт	881,600.00	42,000.00	839,600.0	4.8
70101	<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,250,000.00	8,696,297.00	553,703.0	94.0
70101	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,400,000.00	8,350,297.00	49,703.0	99.4
70101	210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	324,000.00	216,000.0	60.0
70101	210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	00.00	120,000.0	0.0
70101	210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,000.00	00.00	102,000.0	0.0
70101	210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	22,000.00	66,000.0	25.0
70101	<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14000000.00	11122224.00	2,877,776.0	79.4
70101	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	9,122,324.00	2,877,676.0	76.0
70101	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,999,900.00	100.0	100.0
70101	<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11600000.00	10592000.00	1,008,000.0	91.3
70101	<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,600,000.00	10,592,000.00	1,008,000.0	91.3

70101	213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	8,992,000.00	1,008,000.0	89.9
70101	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,600,000.00	0.0	100.0
70101		<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	147,443,200.00	132,658,800.00	14,784,400.0	90.0
70101	<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	147,443,200.00	132,658,800.00	14,784,400.0	90.0
70101	132001	Орон нутгийн төсвөөс	147,443,200.00	132,658,800.00	14,784,400.0	90.0
	<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	0.0	100.0
	610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.0	100.0
	<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	05.00	05.00	0.0	100.0
	620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
	620002	Гүйцэтгэх ажилтан	02.00	02.00	0.0	100.0
	620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.0	100.0
	620004	Гэрээт ажилтан	01.00	01.00	0.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>46,446,172.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>46,446,172.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	46,446,172.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	0.00	40,872,272.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	40,872,272.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	5573900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	5,573,900.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	47553494.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	47,553,494.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	47,553,494.00

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ИТХ-ын Ажлын албаны дарга А.Анхтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 17-ноос 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт ажилтан Ц.Лүндэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд сумын ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 20-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зорилт 1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны үйл ажиллагааг сумын хөгжлийн зорилтуудыг сайтар хэрэгжүүлэхэд чиглүүлэн хүртээмжтэй зохион байгуулан, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.
- Зорилт 2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны үйл ажиллагааг шуурхай хангаж, ИТХ-д хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргийн хүрээнд орон нутаг болон иргэдийн ашиг сонирхолд нийцүүлсэн бодлого боловсруулж оновчтой шийдвэр гарган ажиллана.
- Зорилт 3. Төлөөлөгч, хурлын хороодыг идэвхжүүлэн Хуралд хуулиар олгогдсон хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэн хуулийн хэрэгжилт, сумын эдийн засгийн чадавхыг сайжруулахад нөлөөлж ажиллана.
- Зорилт 4. Хурлын төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төлөөлөгч иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн идэвх оролцоог дээшлүүлнэ.
- Зорилт 5. ИТХ-ын үйл ажиллагаа, гарсан шийдвэрийг олон нийтэд шуурхай хүргэж, тэмдэглэлт өдөр, хууль тогтоомжийг сурталчлах нөлөөллийн ажлуудыг хийн Хурал, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулна.
- Зорилт 6. Хурлын ажлын албаны шуурхай байдлыг ханган нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд шаардагдах ажлыг зохион байгуулна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Замын-Үүд сумын ИТХ санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн цэвэр хөрөнгийн 62,655.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 626.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 97,739.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 977.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сайншанд сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 908.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	1 000.0	1 000.0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	2 381.1	1 534.9	-846.2
Үндсэн хөрөнгө	59 279.8	59 915.4	635.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>61 660.9</b>	<b>62 450.3</b>	<b>789.4</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	61 660.9	62 450.3	789.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>61 660.9</b>	<b>62 450.3</b>	<b>789.4</b>

Авлага дансны үлдэгдэл 1 000.0 мянган төгрөг болж 1 000.0 мянган төгрөгөөр өссөн нь шуудан холбооны зардлын авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 1 534.9 мянган төгрөг болж 846.2 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын зарлагаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 59 915.4 мянган төгрөг болж 5 289.0 мянган төгрөгөөр өсөж, 0.4 мянган төгрөгөөр буурсан нь шинэ хөрөнгийн худалдан авалт болон акталсан хөрөнгөнөөс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 5 289.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө нь акталсан 0.4 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 62 450.3 мянган төгрөг болж 789.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

ИТХ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 19 508.7 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс орлого буурсан нь өмнөх онд тайлант оноос өндөр төсөв баталсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 4 826.7 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна. Төлөвлөлтийг тооцоо судалгаан дээр үндэслэж бодитой тооцоогүйгээс өмнөх оны зардлын төсөв өндөр байсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 173,666.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 173,666.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн дүнгээр сумын ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 12/05 дугаар тогтоолоор ИТХ-ын төсвийг баталсан ба 2020 оны 12 сарын 09-ний өдрийн 02/12 дугаар тогтоолоор 147,443.2 мянган төгрөг болгон анхны баталсан төсвийг 26,222.9 мянган төгрөгөөр бууруулж өөрчилсөн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 147 443.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 147 443.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 132,658.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 0 мянган төгрөг, нийт 132,658.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 132,417.7 мянган төгрөгийг зарцуулж 241.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 132,417.7 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байгаа нь санхүүжилт дутуу олгогдсонтой холбоотой байна.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас олон нийтийн цагдаагийн урамшуулалд 47,553.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байгууллагын чиг үүргийн хүрээнд 46,446.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,107.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 8,531.0 мянган төгрөгийн буюу 2019 оны аудитаар 751.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2020 оны аудитаар 7,780.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 6,700.0 төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн бөгөөд 1,080.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 6,700.0 мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмжийг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	1831.0	1	1080.0	1	751.0	41.0
Албан шаардлага	1	6700.0	1	6700.0	0	0	0
Зөвлөмж	1		1		0	0	0
Нийт дүн	4	8531.0	4	7780.0	1	751.0	41.0

/мянган.төг/

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,164.0 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 5,164.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 2 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайланд цалингийн зардлын дүн 72,469.7 мянган төгрөг, ҮДТ-нд 76,238.6 мянган төгрөгөөр тайлагнагдсан ба цалингийн зардлын дүнг 3,768.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна. ҮДТ-нд цалингийн зардлын дүнг 3768.9 мянган төгрөгөөр бууруулж залрууллаа.

2. Мобикомд корпорацид 1,000.0 мянган төгрөгийг шуудан холбоо, интернэтийн төлбөрийн зардлаас урьдчилж шилжүүлсэн бөгөөд зардал гарсан тухай холбогдох анхан шатны нотлох баримт байхгүй байна. Үүнд Мобикомд корпорациас 1,000.0 мянган төгрөгийн авлага үүсгэж санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланд залрууллаа.

3. Санхүүгийн байдлын тайлангийн ажилчидтай холбогдсон өглөгийн үлдэгдэл хасах 395,075 төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. Татвараас авах ХХОАТ болох 395,075 төгрөгийг санхүүгийн байдлын тайланд авлагын үлдэгдлээр залрууллаа.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар төлбөрийн акт биелүүлээгүй зөрчил илэрсэнд сахилгын шийтгэл ногдуулах нэг албан шаардлага хүргүүлээ.

1. Өмнөх 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар ажил гүйцэтгэх гэрээний дүнгээс илүү олгосон мөнгийг төлүүлэх тухай 751.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, **төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй**, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42.3.Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгнө гэж заасны дагуу сумын ИТХ-ын даргад албан шаардлага өглөө.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар төсвийн төлөвлөлтийг бодитой, тооцоо судалгаан дээр үндэслэсэн байдал, тээврийн хэрэгслийн хувийн хэрэг хөтлөлт, сэлбэг шатахууны норм мөрдөж буй эсэхийг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### *Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Урсгал үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг анхан шатны баримт болон журналаас шүүж төсвийн гүйцэтгэлтэй тулгахад оюутны тэтгэлэгт хөтөлбөрийн дэмжлэгт /сургалтын төлбөр/ 9992.0 сая төгрөг, ИТХ-ын хуучин, шинэ төлөөлөгчдийн хүндэтгэлийн арга хэмжээнд 7671.7 мянган төгрөг, Түмэн-Од хөл бөмбөгийн клубт дэмжлэг 500.0 мянган төгрөг, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтгүйгээр суудлын авто машинд 2776.0 мянган төгрөгийн 4 дугуй авсан зэрэг нийт 20939.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулах, үнэн зөв байдал батламж мэдэгдэл хангагдахгүй байх

- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1, 25.10 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.22	Аудитын нэр: Замын-Үүд сумын ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/36/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Замын-Үүд сумын ИТХ	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Сахилгын шийтгэл ногдуулах		Албан шаардлага өгсөн	Ажлын албаны дарга, нягтлан бодогч	А.Анхтуяа, Н.Тунгалаг
2	Үр ашиггүй зарцуулсан, тусламж олгосон		Зөвлөмж өгсөн	Ажлын албаны дарга, нягтлан бодогч	А.Анхтуяа, Н.Тунгалаг
<b>ДҮН</b>		<b>0</b>			